

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЗАСАГЛАЛ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ**

2024 он

Баруун-Урт сум

№	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022	Зорилтот түвшин тухайн Жил	Хүрсэн түвшин	Хэрэгжилт, тайлбар	Үнэлгээ
1	Иргэд, ААН болон харилцагч бусад байгууллагаас гаргасан нийт хүсэлт, гомдлыг хуулийн хугацаанд бодитой шийдвэрлэсэн асуудлын эзлэх хувь	Гал түймэр гарсан тухай акт 17, галын шинжээчийн дүгнэлт 7 үйлдсэн байна. гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн акт 9 гаргасан гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн акт 9 гаргасан	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах 179 иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтийг хүлээн авч барилга байгууламжийн галын аюулгүй байдалд “Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм журам түүнтэй нийцүүлэн гаргасан норм, стандартын хэрэгжилт галын аюулаас хамгаалагдсан байдалд хяналт шалгалт хийж Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны А/154 дугаар тушаалын дагуу Ажлын байрны галын аюулгүй байдлын 162 дүгнэлтийг олгож, илэрсэн зөрчил дутагдалд зөрчлийг шийдвэрлэн тэмдэглэл хөтлөж ажиллаж байна. Гал түймэр гарсан тухай акт 17, галын шинжээчийн дүгнэлт 7 үйлдсэн байна. Гамшгаас хамгаалах улсын хяналтын	33	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах 174 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг хүлээн авч барилга байгууламжийн галын аюулгүй байдалд “Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм журам түүнтэй нийцүүлэн гаргасан норм, стандартын хэрэгжилт галын аюулаас хамгаалагдсан байдалд хяналт шалгалт хийж МУ-ын Шадар сайдын 2023 оны 75 дугаар тушаалын дагуу Ажлын байрны галын аюулгүй байдлын 166 дүгнэлтийг олгож, илэрсэн зөрчил дутагдалд зөрчлийг шийдвэрлэн тэмдэглэл хөтлөж ажиллаж байна.	100

			байцаагчийн акт 9 гаргасан			
2	Төсвийн орлого бүрдүүлэлт (сая төг.)	-	-	-	Үндсэн үйл ажиллгааны орлогын бүрдүүлэлт байхгүй 100 хувь улсын төсвөөс санхүүжинэ.	-
3	Төсвийн хэмнэлт (хувь)	2023 онд төсвийн хэмнэлт байхгүй батлагдсан төсвийг 100% захиран зарцуулсан.	2024 оны батлагдсан төсвийг үр ашигтай захиран зарцуулах.	100	2024 оны 11 сарын төсвийн гүйцэтгэлийн байдлаар төсвийн хэмнэлт 6% байна. Уг хэмнэлт нь орон тоо дутуу байгаатай холбоотой цалингийн хэмнэгдсэн зардал байна.	100
4	Өмч ашиглалт, хадгалалт, худалдан авалтын үр дүн	2023 онд байгууллагын өмч хөрөнгө хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, хагас бүтэн жилд эд хөрөнгийн тооллого 2 удаа хийгдсэн	2024 онд өмч хөрөнгөнд хяналт тавих, ашиглагдахгүй хөрөнгийг актлах.	100	2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлантай холбогдуулан Онцгой байдлын газрын даргын 2024 оны А/68 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг үндсэн болон эргэлтийн хөрөнгийг нэг бүрчлэн тоолж, данс бүртгэлтэй тулган баталгаажуулж хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, заавар зөвлөгөө өгсөн. Онцгой байдлын ерөнхий газар, бусад анги, салбаруудаас хүлээн авсан хувцас хангалт, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг тухай бүр нь анхан шатны баримтыг үндэслэн тооцоо нийлж баталгаажуулан, санхүүгийн тайлан бүртгэлд тусгаж ажилласан. Бараа материалын худалдан авалтыг тухай бүр нь санхүүгийн бүртгэлд тусгаж ажилласан.	100
5	Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийн талбай /мод, бут, сөөгний тоо/	Баруун-Урт сумын 5-р тойргийн хувиарт нийт 360 модыг усалгаа арчилгааг тогтмол хийж ажилласан.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	100	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2021 оны 58 дугаар зарлигаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Онцгой байдлын газрын хэмжээнд хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрөөр хийгдэх ажлын	100

					төлөвлөгөөг гаргаж батлуулж мод тарих ажлыг газрын хэмжээнд зохион байгуулж ажиллалаа. Онцгой байдлын газрын алба хаагчид Түмэнцогт сум дахь үрслэгээний талбайгаас гүйлс-370 ширхэг, хайлаас-100ш, улиас- 260 ширхэг, чацарганын суулгац-120 ширхгийг шилжүүлэн нөхөн сэргээлт хийж байгууллагын эзэмшлийн талбайд алба хаагчдын гэр бүл, ахмад ажилчдын хамт нийт-970 ширхэг модыг /3,880,000 сая төгрөгөөр / тарих ажлыг зохион байгуулан усалгаа, арчилгааг хийж гүйцэтгэлээ.Мөн байгууллагын алба хаагчдын хувийн эзэмшлийн хашаанд мод тарих боломжоор хангаж байгууллагын үрслэгээний талбайгаас 120 ширхэг гүйлс модны үрсэлгээг анги,салбар нэгжийн алба хаагчдад тарааж гэр, бүлийн хүрээнд мод ажлыг зохион байгуулсан.Түмэнцогт сум дахь мод үржүүлгийн талбайд 0,5 гр хайлаас үр суулгаж 300 гаруй ширхэг хайлаас мод тарьц бэлдэж, 3кг гүйлсний үр суулгаж 1500 гаруй ширхэг гүйлсний тарьц бэлдэж ургалт одоогийн байдлаар 50%-тай байна.	
6	Ахуйн түймрийн гаралт хохирол /төгрөгөөр/	28 удаагийн объектийн түймэр гарч, 222.130.000 төгрөгийн хохирол учирч, 544.900.000 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан	32 удаагийн объектийн түймэр гарч, 1,924,000,000₮ сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан	100	Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар 2024 онд 32 удаагийн объектын гал түймэр дуудлагаар ажиллаж ард иргэдийн гэр-5, барилга, байшин-15, машин-3, малын саравч, аргал хөрзөн-2, бусад-7, нийт 1,924,000,000₮ төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан. Гал түймрийг унтраахад 384,9 литр шатахуун, 77.6 тн ус зарцуулж, давхардсан тоогоор 192 алба хаагч, нийт 10 цаг 58 минут ажиллаж гал	100

					түймрийг бүрэн унтраасан байна.	
7	Ой хээрийн түймэр хохирол /төгрөгөөр/	19 удаагийн хээрийн түймэр гарч, байгаль экологид 479.2 сая, 84.1 мянган га талбай шатаж, эд хөрөнгө 4.1 сая, түймэр унтраахад гарсан зардал 15.3 сая төгрөгний хохирол учирсан.		100	Хээрийн түймэр 29 удаа гарч байгаль экологид 96.809га талбай шатаж 480.292.200 төгрөгийн хохирол учирсан байна. Түймэр унтраахад гарсан зардал 5.828.116 төгрөг.	100
8	Гамшиг ослын тоо	72	Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг бүх хэлбэрээр явуулж гамшиг ослын тоог бууруулах	205	Мөн тус газар нь 2024 онд 92 удаагийн гамшиг осол, хээрийн түймрийн дуудлагаар ажилласан байна. Тус бүрээр ангилж үзвэл хээрийн түймэр дуудлагаар-28 удаа, цасны дуудлагаар 51 удаа, хүний эрлийн дуудлагаар 4 удаа, үер усны дуудлагаар 3 удаа, авто ослын дуудлага 2 удаа тус тус үүрэг гүйцэтгэж давхардсан тоогоор 611 алба хаагч ажиллаж 550 хүний амь нэс, буцалтгүй нэрвэгдэгч-6, эд хөрөнгө авран хамгаалсан.	100
9	Гамшгаас урьчилан сэргийлэх талаар зохион байгуулсан арга хэмжээний тоо	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоогоор буюу сард 3 удаа	Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах	38	Монгол Улсын шадар сайд, ОБЕГ-ын даргын баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал”, “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлье”, Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлье”, “Үер усны ослоос урьдчилан сэргийлье”, Гамшгийн эрсдэлийн бууруулах Олон улсын өдөр” нэгдсэн арга хэмжээний удирдамж, Улсын Онцгой комиссын	90

					01, 02 тоот албан даалгаврын хүрээнд хүрээнд аймгийн болон 13 сумын Засаг даргын Тамгын газар, “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газар, “ДБЭХС,ТӨХК-ийн Сүхбаатар салбар, Улаан загалмайн хороо, Японы хүүхдийг ивээх сантай хамтран олон нийтийг гал түймэр, гамшгийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажилласан. 2024 онд Сүхбаатар аймгийн хэмжээнд хээрийн түймэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 52,6 хувиар өсөж, өртсөн га талбай 41 хувиар буурсан. Объектын түймэр 0,25 хувиар буурсан. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн А/135 дугаар тушаал “гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулах заавар”-н дагуу Гал түймэр унтраах, аврах 15 анги нь Баруун-Урт сумын 48 аж ахуй нэгж байгууллагад, Гал түймэр унтраах, аврах 47 дугаар анги нь Эрдэнэцагаан сумын 36 аж ахуй нэгж байгууллагад /Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын тоотой холбогдуулан боловсруулав/ гал түймэр унтраах тархалтын дадлага сургалтын төлөвлөгөөний хуваарь гаргаж газрын даргаар батлуулан хуваарийн дагуу Баруун-Урт, Эрдэнэцагаан сумын аж ахуй нэгж байгууллагад Тархалтын дадлага сургалтыг 84 удаа, Тактикийн дадлага сургалтыг 8 удаа тус тус зохион байгуулсан.	
--	--	--	--	--	---	--

10	Гамшиг осол	Гамшиг, осол, гал түймэр болон бусад төрлийн нийт 68 удаагийн мэдээ, мэдээлэл, дуудлага, бүртгэгдсэн	Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг бүх хэлбэрээр явуулж гамшиг ослын тоог бууруулах	Гамшиг, осол, гал түймэр болон бусад төрлийн нийт 164 удаагийн мэдээ, мэдээлэл, дуудлага, бүртгэгдсэн.	2024 онд аймгийн хэмжээнд Асгат, Дарьганга, Мөнххаан, Уулбаян, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын нутагт нийт 29 удаагийн хээрийн түймрийн дуудлагаар ОБГ-аас 323 алба хаагч 35 техник, мэргэжлийн анги болон орон нутгийн 615 албан хаагч, иргэн 167 автомашин, 57 мотоцикль, ажиллаж удирдлага зохион байгуулалтад оруулан тактикийн алдаа дутагдалгүй зохион байгуулж ажилласан.	100
	Дундаж оноо					

СҮХБААТАР АЙМАГ ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР